

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 416

Арвайхээр

Коронавируст халдвар (Ковид-19)-ын
эсрэг “Комирнэти” (BN162B2) вакцинаар
дархлаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5в, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг “Комирнэти” (BNT162b2) вакцинаар дархлаажуулах тухай” А/337 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг Пфайзер-БиоН”Тех үйлдвэрийн “Комирнэти (BNT162b2) вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Олон улсын КОВАКС хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа коронавируст халдвар КОВИД-19)-ын эсрэг Пфайзер-БиоН” Тех үйлдвэрийн “Комирнэти” (BNT162b2) вакцинаар архаг хууч өвчтэй, байнгын асаргаанд байдаг, хүндэтгэх шалтгаантай иргэд, хөхүүл болон жирэмслэлтийн үеийн эрсдлийг тооцож жирэмсэн эмэгтэйчүүдийг сайн дурын үндсэн дээр тархвар судлалын заалтаар вакцинжуулах ажлыг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалтыг удирдан зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), зорилтот бүлгийн иргэдээс урьдчилан зөвшөөрөл авч вакцинжуулах, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын хэрэгжилтийг чанд мөрдөн ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.


ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

13900 019

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 06 сарын 03 ны өдрийн 116 дугаар тушаалын хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ПФАЙЗЕР-БИОН” ТЕХ
ҮЙЛДВЭРИЙН “КОМИРНЭТИ (BNT162B2) ВАКЦИН, ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН
ХУВААРЬ

№	№	Зорилтот бүлэг					Шаардагдах				Аюулгүй хайрцаг
		Жирэмсэн	Архаг хууч	Байнгын асаргаанд байдаг иргэд,	Бусад хүндэтгэх шалтгаантай	Хамрагдвал зохих нийт хүн ам	Вакцин		Тариур		
							Нийт хүн тун /2 тун/	Флакон 1 фл-6 хүн тун /2 тун/	0.3 мл /2 тун/	2 мл /2 тун/	
2	Баруунбаян-Улаан			11	25	36	72	12	72	12	1
3	Бат-Өлзий			20	22	42	84	14	84	14	1
4	Баянгол			10	2	12	24	4	24	4	1
5	Баян-Өндөр			21	9	30	60	10	60	10	1
6	Богд			31	35	66	132	22	132	22	1
7	Бүрд			14	40	54	108	18	108	18	1
8	Гучин-Ус			6	0	6	12	2	12	2	1
9	Есөн-зүйл			32	28	60	120	20	120	20	1
10	Зүүнбаян-Улаан			25	5	30	60	10	60	10	1
11	Нарийнтээл			15	15	30	60	10	60	10	1
12	Өлзийт			12	0	12	24	4	24	4	1
13	Сант			24	6	30	60	10	60	10	1
14	Тарагт			6	6	12	24	4	24	4	1
15	Төгрөг			4	8	12	24	4	24	4	1
16	Уянга			42	0	42	84	14	84	14	1
17	Хайрхандулаан			24	0	24	48	8	48	8	1
18	Хархорин	120		130	50	300	600	100	600	100	6
19	Хужирт			15	15	30	60	10	60	10	1
20	нарны дөш	120		142	50	312	624	104	624	104	6
21	Уян сэтгэл	110		106	72	288	576	96	576	96	5
22	Түшигдөлгөөн	98		83	41	222	444	74	444	74	4
	Нийт	448		773	429	1650	3300	550	3300	550	38